

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр

№ТУЗТ 10/2021

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн энгийн хувьцаа худалдах,
сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5, 5.8 дах хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 55 дугаар зүйл, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.8, 76.1.17, 76.2 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дах хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.7, 9.10.14, 9.10.17, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн эзэмшиж буй “Мөнгөн морь констракшн” ХХК-ийн 65 /жаран тав/ хувь буюу 1 /нэг/ ширхэг нь 1/нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 261'664'000/хоёр зуун жаран нэгэн сая зургаан зуун жаран дөрвөн мянга/ ширхэг-энгийн хувьцаа нэг бүрийг 1,17 /нэг төгрөг арван долоон мөнгө/ төгрөгөөр нийт 306'146'880 /гурван зуун зургаан сая нэг зуун дөчин зургаан мянга найман зуун ная/ төгрөгөөр иргэн Б.Батхүүд буцаан худалдахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.
2. “Мөнгөн морь констракшн” ХХК-ны бусад хувьцаа эзэмшигчид энэ тогтоолын 1-т заасан хувьцааны тоо ширхэг, нэг бүрийн болон нийт үнээр тэргүүн ээлжид худалдаж авч болох хугацааг ажлын 15 хоногоор, “Мөнгөн морь констракшн” ХХК-д мэдэгдэх хугацааг ажлын 5 хоногт багтаан мэдэгдсүгэй.
3. Компани болон иргэн Б.Батхүүгийн хооронд байгуулагдах “Мөнгөн морь констракшн” ХХК-ны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/